



Хичээлийн сэдэв: СОНГУУЛЬ, СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО



Хичээлийн зорилго



**СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО ГЭЖ ЮУ БОЛОХ, ТЭДГЭЭРИЙН
ДАВУУ БОЛОН СУЛ ТАЛУУДЫГ ХАРЬЦУУЛАХ**



Үнэлж
дүгнэх

Асуудал
дэвшүүлэх

Харьцуулан
шинжлэх



Сонгууль, сонгуулийн тогтолцоо



Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.

Монгол Улсын Үндсэн хууль 3-р зүйл

Ард түмэн засгийн эрх барихын мөн чанар нь чөлөөт, шударга, ардчилсан сонгуулийг тогтмол хугацаанд явуулж өөрсдийн төр засаг, төлөөлөгчдийг сонгодогт байгаа юм.

Сонгууль, сонгуулийн тогтолцоо

Сонгууль (англ. Election) гэдэг нь ямарваа нэг хувь хүн өөрийн биеэр хараат бусаар, өөрийн бодлоор тодорхой түвшний олон нийтийн удирдлагыг (жишээлбэл Улсын их хурлын сонгууль) сонгох цогц үйл явц юм. Энэ нь XVII зуунаас хойш төлөөллийн ардчиллыг хэрэгжүүлэх үндсэн оньс болсоор ирсэн юм.

(<https://mn.wikipedia.org/wiki/%D0%A1%D0%BE%D0%BD%D0%B3%D1%83%D1%83%D0%BB%D1%8C>)

Улс төрийн хувьд сонгууль гэдэг нь санал хураалт явуулах замаар улс төрийн сонголт хийхийг хэлнэ.



Сонгууль, сонгуулийн тогтолцоо

- Аль ч улс оронд төрийн эрх мэдэл дээд тэнгэрээс сурвалжтай хэмээн үзэж байсан үе бий.



Францын хаан Людовик XIV

- XVII зуунаас баруун Европт төрийн эрх мэдэл гагцхүү ард түмнээс, тэдний итгэл зөвшөөрлөөс үүсэлтэй гэсэн үзэл баримтлал давамгайлах болсон.



Сонгууль, сонгуулийн тогтолцоо

СОНГУУЛИЙН ЭРХ

Сонгох
эрх

- 2 ба түүнээс дээш нэр дэвшигч эсвэл улс төрийн намаас сонголт хийх иргэний эрх

Сонгогдох
эрх

- Иргэний төрийн байгууллагын бүрэлдэхүүнд сонгогдох эрх




Сонгууль, сонгуулийн тогтолцоо



Ардчилсан сонгуулийн зарчим

Сонгууль, сонгуулийн тогтолцоо



БНМАУ-ын Ардын Их Хурлын депутатуудын 12 дахь, аймаг, хот, сум, хороо, район, орон нутгийн хотын Ардын Хурлын депутатуудын 16 дахь удаагийн сонгуулийг 1990 оны долдугаар сарын 29-ний ням гаригт явуулсан байна.

СОНГОХ ЭРХИЙН ШАЛГУУР

Нас- Ихэнх улс оронд 18 наснаас сонгох эрх эдэлдэг.

Санал өгөх эрх зүйн чадамжгүй байх-
Хорих ял эдэлж байгаа, эрх зүйн
чадамжгүй нь шүүхээр тогтоогдсон үед

Монгол Улсад 18 насанд хүрсэн, санал
өгөх эрх зүйн чадамж бүхий иргэд
саналаа өгөх эрхтэй.

СОНГОГДОХ ЭРХИЙН ШАЛГУУР

Нас- Сонгогдох албан тушаалтны ажлын
байрны онцлогоос хамааран өөр өөр
байдаг

Тусгай шаардлага- Зарим үед
сонгонгдох албан тушаалын онцлогоос
хамааран тусгай шаардлага тавьж
болдог.

УИХ-д 25, ерөнхийлөгчид 45 нас хүрсэн,
санал өгөх эрх зүйн чадамж бүхий иргэн
сонгогдох эрхтэй.
Ерөнхийлөгчид нэр дэвшигч нь Монгол
Улсын уугуул иргэн, сүүлийн 5 жил эх
орондоо тогтвор суурьшилтай
амьдарсан байх ёстой.

Сонгууль, сонгуулийн тогтолцоо

- ❖ Улс төрийн шинжлэх ухаанд сонгуулийг санал хураалт явуулах замаар улс төрийн шийдвэр гаргах үйл явц гэж тодорхойлдог.
- ❖ Сонгууль явуулах, санал авах, дүн гаргах, парламентын суудал хуваарилах арга, дүрэм журмын цогцыг **сонгуулийн тогтолцоо** гэнэ.

01 МАЖОРИТАР – ОЛОНХИЙН



02 ПРОПОРЦИОНАЛЬ – ХУВЬ ТЭНЦҮҮЛЭХ



Сонгууль, сонгуулийн тогтолцоо

01 МАЖОРИТАР ТОГТОЛЦОО ЯМАР ХЭЛБЭРҮҮДТЭЙ ВЭ?

- А. ЭНГИЙН ОЛОНХ- 50-С ДЭЭШ ХУВИЙН САНАЛ АВСАН
- В. ХАРЬЦАНГУЙ ОЛОНХ- ХАМГИЙН ОЛОН САНАЛ АВСАН
- С. ҮНЭМЛЭХҮЙ ОЛОНХ- НИЙТ САНАЛЫН $\frac{3}{4}$ БУЮУ 75 ХУВЬ, $\frac{3}{2}$ БУЮУ 66 ХУВИАС ДЭЭШ САНАЛ АВСАН НЭР ДЭВШИГЧИЙГ ЯЛСАНД ТООЦОХ АРГА

МАЖОРИТАР ТОГТОЛЦООГ ХЭРЭГЖҮҮЛДЭГ УЛС ОРНУУД: АНУ,
АНГЛИ, ФРАНЦ, ЭНЭТХЭГ, МЕКСИК



Сонгууль, сонгуулийн тогтолцоо

МАЖОРИТАР ТОГТОЛЦООНЫ ДАВУУ ТАЛ ЮУ ВЭ?

- ✓ Энгийн ойлгомжтой
- ✓ Тогтвортой засгийн газар
- ✓ Шууд сонгох
- ✓ Тойргийн сонгогчдын хариуцлага

МАЖОРИТАР ТОГТОЛЦООНЫ СУЛ ТАЛ ЮУ ВЭ?

- Санал гээгддэг
- Цөөн төлөөллөөр олонх болдог
- Нэг нам эсвэл хоёр намын тогтолцоо
- Популистууд гарах
- Парламентч тойргийн сонгогчдоос хараат
- Нутгархаг сэтгэл зүй
- Намын сахилга хариуцлага сулардаг



Сонгууль, сонгуулийн тогтолцоо

ПРОПОРЦИОНАЛЬ ТОГТОЛЦООНЫ ДАВУУ ТАЛ ЮУ ВЭ?

- ✓ Санал гээгддэггүй
- ✓ Саналын төлөөлөл алдагддаггүй
- ✓ Улс төрийн хүчний зохистой харьцаа хангагддаг
- ✓ Парламент ёс хөгжих
- ✓ Намуудын төлөвшилд сайн нөлөөтэй
- ✓ Хариуцлага хүлээх субъект тодорхой
- ✓ Улс төрийн соёл боловсролын өндөр түвшин

ПРОПОРЦИОНАЛЬ ТОГТОЛЦООНЫ СУЛ ТАЛ ЮУ ВЭ?



- Хэт олон сул нам бий болох
- Жижиг намууд парламентад орж ирэх
- Тогтворгүй засгийн газар
- Бие даасан нэр дэвшигчдэд халгаатай
- Намчирхах сэтгэлзүй нэмэгдэх
- Орон нутгийн төлөөлөл, ашиг сонирхлыг хангах чадвар сул
- Сонгогчдоос гишүүнд хяналт тавих боломж сул



Сонгууль, сонгуулийн тогтолцоо

ХОЛИМОГ ТОГТОЛЦОО

- ❑ Холимог тогтолцоонд өөр өөр томъёололтой сонгуулийн хоёр тогтолцоог зэрэгцүүлэн ашигладаг. Үүнд санал өгөх сонгогчид ижил байх бөгөөд төлөөлөгчдийг гол төлөв нэг мандаттай тойрог бүхий харьцангуй олонхын болон намын жагсаалтаар санал хураах хувь тэнцүүлэх системийг хослуулан сонгодог.



https://en.wikipedia.org/wiki/Electoral_system

Сонгууль, сонгуулийн тогтолцоо



Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо нь Улсын Их Хурлын болон Ерөнхийлөгчийн сонгууль, ард нийтийн санал асуулгыг улс орон даяар удирдан зохион байгуулж явуулах бүрэн эрхтэй бөгөөд үйл ажиллагаагаа бие даасан, хараат бус, хамтын удирдлагын зарчмаар явуулдаг, байнгын ажиллагаатай төрийн байгууллага юм.

НУУЦ САНАЛ ХУРААЛТ

Иргэний үнэмлэхээ авч сонгуулийн байранд ирнэ.


Үнэмлэхийг сонгогчдын нэрийн жагсаалттай тулгана.

Саналын хуудас авна.

Саналаа өгнө.


Саналын машинд саналаа хийнэ.

Сонгууль, сонгуулийн тогтолцоо



Сонгууль, сонгуулийн тогтолцоо

УИХ-ЫН 8 ДАХ УДААГИЙН СОНГУУЛИЙН ҮР ДҮН, ТООН МЭДЭЭ



3. Хэрвээ хувь тэнцүүлсэн тогтолцоогоор тооцвол:



Сонгууль, сонгуулийн тогтолцоо

2019-А-32. Иргэн хүн сонгуульд оролцох нь нийгмийн аль хүрээний харилцаанд хамаарагдах

вэ

A

Социал хүрээ

B

Улс төрийн хүрээ

C

Эдийн засгийн хүрээ

D

Хүмүүнлэгийн хүрээ

E

Оюун санааны хүрээ ийн сонголтоор саналаа өгөх боломжтой байх

Сонгууль, сонгуулийн тогтолцоо

2019-А-33. Иргэн хүн сонгуульд оролцох нь нийгмийн аль хүрээний харилцаанд хамаарагдах

вэ

A

Социал хүрээ

B

Улс төрийн хүрээ

C

Эдийн засгийн хүрээ

D

Хүмүүнлэгийн хүрээ

E

Оюун санааны хүрээ ийн сонголтоор саналаа өгөх боломжтой байх

Сонгууль, сонгуулийн тогтолцоо

2019-B-32. Сонгогч гэж хэнийг хэлэх вэ?

A

Хорих ял эдэлж буй иргэн

B

Аль нэг намын гишүүн

C

25 насанд хүрсэн иргэн

D

Гадаадын харьяат иргэн

E

Сонгуулийн эрх бүхий иргэн нголтоор саналаа өгөх боломжтой байх

Сонгууль, сонгуулийн тогтолцоо

2019-B-33. Намын нэрээр санал хурааж, авсан саналд нь хувь тэнцүүлж суудал хуваарилдаг сонгуулийн тогтолцоо аль нь вэ?

A

Чөлөөт сонгууль

B

Холимог

C

Пропорцианоль

D

Мажоритар

E

Уламжлалт

Эн өөрийн сонголтоор саналаа өгөх боломжтой байх

Сонгууль, сонгуулийн тогтолцоо

2020-A-32. Бүх нийтээр оролцох сонгуулийн зарчмыг тэмдэглэнэ үү.

A Нас хүйс, яс үндэс, мэргэжил, үзэл бодлоос үл шалтгаалан оролцох

B Сонгогч бүр ижил тооны санал гаргах, санал бүр адил жинтэй байх

C Сонгуулийн эцсийн үр дүн нь иргэдийн санал хураалтаар шийдэгдэх.

D Чөлөөтэй сонголт хийн саналаа чөлөөтэй илэрхийлэх боломжтой байх

E Сонгогч зөвхөн өөрийн сонголтоор саналаа өгөх боломжтой байх.

Сонгууль, сонгуулийн тогтолцоо

2020-А-33. Сонгогчдоос 50-аас дээш хувийн санал авсан нэр дэвшигчийг ялсанд тооцдог сонгуулийн тогтолцоо аль нь вэ?

А Саналыг харгалзах

В Харьцангуй олонх

С Үнэмлэхүй олонх.

Д Хувь тэнцүүлэх

Е Энгийн олонх ийн сонголтоор саналаа өгөх боломжтой байх

Сонгууль, сонгуулийн тогтолцоо

2020- В-32. Тэгш оролцох сонгуулийн зарчмыг тэмдэглэнэ үү.

A Сонгуулийн эцсийн үр дүн нь иргэдийн санал хураалтаар шийдэгдэх

B Нас хүйс, яс үндэс, мэргэжил, үзэл бодлоос үл шалтгаалан оролцох

C Сонгогч бүр ижил тооны санал гаргах, санал бүр адил жинтэй байх

D Чөлөөтэй сонголт хийн саналаа чөлөөтэй илэрхийлэх боломжтой байх

E Сонгогч зөвхөн өөрийн сонголтоор саналаа өгөх боломжтой байх

Сонгууль, сонгуулийн тогтолцоо

2020-B-33. Сонгогчдоос хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг ялсанд тооцдог сонгуулийн тогтолцоо аль нь вэ?

A

Хувь тэнцүүлэх

B

Харьцангуй олонх

C

Үнэмлэхүй олонх

D

Энгийн олонх

E

Саналыг харгалзах ийн сонголтоор саналаа өгөх боломжтой байх

EDUCATION
IS THE MOST
POWERFUL WEAPON
WE CAN USE
TO CHANGE THE WORLD

— NELSON MANDELA

